



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АРА-2024/20-1-
ШТА-ГА



Архангай аймаг
2024 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Б.Азантунгалаг
Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn
Аудитор Б.Анхтуяа
Утас: 99412231 Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
<i>Хүснэгтийн товъёо</i>	3
<i>Дүрслэлийн товъёо</i>	3
<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээгдэл</i>	6
<i>Ерөнхий мэдээлэл</i>	7
1 БҮЛЭГ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ АЖИЛЛААГҮЙГЭЭС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭЭГҮЙ БАЙНА	8
<i>1.2 Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд нь хүүхэд хамгааллын мэргэжилтний жишиг нормативгүйгээс хүний нөөц хүртээмжгүй, бусад байгууллагуудтай харилцан уялдаатай ажиллаагүй байна.</i>	13
2 БҮЛЭГ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛААР БАТЛААГҮЙ БАЙНА	17
<i>2.1. Хүүхэд хамгааллын зардлыг төсвийн төсөлд үндэслэн олгоогүй байна.</i>	19
<i>2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийг батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулж ил тод тайлагнасан байна.</i>	20
3 БҮЛЭГ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА	24
<i>3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд тавих хяналтын үр дүн хангалтгүй байна</i>	28
<i>3.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хэдий ч хүүхдийн эрхийн зөрчил буураагүй байна.</i>	31
<i>3.3. Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэмт хэргийн суурь шалтгааныг судлаагүй байна.</i>	33
ДҮГНЭЛТ	37
ЗӨВЛӨМЖ	38
ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР	



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОБГ	Онцгой байдлын газар
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар



Хүснэгтийн товч

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний тоо	9
Хүснэгт 1	Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль цэцэрлэгт хамрагдалт	11
Хүснэгт 2	Архангай аймгийн 2019-2023 оны Дотуур байрны сурагчдын тоон үзүүлэлт	11
Хүснэгт 3	Архангай аймгийн хэмжээний 2019-2023 оны хурдан морины уралдаанч хүүхдүүдийн тоон үзүүлэлт	13
Хүснэгт 4	Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны зардлын төсвийн төсөл, батлагдсан төсөв	18
Хүснэгт 5	Аймгийн ХГБХХГ-ын 2023 оны төсвийн төсөл	18
Хүснэгт 6	Урьдчилан сэргийлэх сургалт арга хэмжээ, хүүхэд холбогдсон гэмт хэргийн тоо	19
Хүснэгт 7	2019-2023 оны батлагдсан төсөв	20
Хүснэгт 8	Хүүхэд хамгааллын зардлын санхүүжилтийн эх үүсвэр	21
Хүснэгт 9	Аймгийн ХГБХХГ-ын зориулалт бус зардал	21
Хүснэгт 10	Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч болон зардлын тооцоо	23
Хүснэгт 10	Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалт	21
Хүснэгт 11	Аймгийн ЗДТГ, Дотоод хяналт-шинжилгээний үнэлгээний хувь	27
Хүснэгт 12	ЭМГ-т ирсэн өргөдөл гомдлын мэдээ	30
Хүснэгт 13	Аймгийн ХГБХХГ-ын 108 утасны дуудлага мэдээллийн тоо	33
Хүснэгт 13	Түр хамгаалах байранд үзүүлсэн үйлчилгээ	35
Хүснэгт 14	Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон болон холбогдсон хүүхдийн тоон мэдээ	36
Хүснэгт 15	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс гарсан сургалтын мөнгөн дүн, тоо	37
Хүснэгт 15	Аймгийн эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн тоон мэдээлэл	38



Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл-1	Аймгийн нийт хүүхдийн тоон мэдээлэл	11
Дүрслэл-2	Аймгийн ХГБХХГ-ын орон тооны мэдээлэл	17
Дүрслэл-3	Аймгийн хамтарсан багийн нийгмийн ажилтны мэдээлэл	17
Дүрслэл-4	Гэр бүлийн орчинд үйлдэгдсэн 108 утасны дуудлага мэдээлэл	29



Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилго оршлоо. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ <i>Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх,</i> ➤ <i>Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх,</i> ➤ <i>Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр дүнтэй эсэх.</i>
Аудитын хамарсан хүрээ	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.



Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа.Үүнд: • Хүүхдийн эрхийн тухай конвенц, • Монгол Улсын Үндсэн хууль, • Хүүхэд хамгааллын тухай хууль, • Хүүхдийн эрхийн тухай хууль, • Гэр бүлийн тухай хууль, • Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, • Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, • Боловсролын тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Шилэн дансны тухай хууль, • Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, • Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”, • Архангай аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Архангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон холбогдох бусад баримт материалууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Байгалмаа удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Б.Анхтуяа, аудитор Б.Азантунгалаг нар 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	Аудитын явцад шалгагдагч байгууллагаас ирүүлсэн статистик тоо мэдээ зөрүүтэй, мэдээг жил бүр албажуулан хадгаламжийн нэгж болгоогүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсний баримт материалыг архивын нэгж болгодоггүй зэрэг хүндрэл бэрхшээлүүд үүсэж байлаа.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд хамгааллын тухай хууль нь 2016 онд батлагдсанаас хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөж ажиллажээ. Хуулийн шинэчилсэн найруулга 2024 онд батлагдан 09 дүгээр сарын 01-ээс эхлэн хэрэгжиж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.2-т хүүхэд хамгаалал гэдэг нь “нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээ” гэж тодорхойлсон байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 16.4.1¹ - д тодорхойлсноор аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын бодлогыг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/75 дугаар захирамжаар "Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм"-ийг, 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/163 дугаар захирамжаар хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ.

Хүүхэд хамгааллын бодлого нь:

1. Гэр бүлийн дэх хүүхэд хамгаалал,
2. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал
3. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал
4. Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал
5. Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал
6. Гамшиг, гамшигын онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал
7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал бөгөөд орон нутгийн хэмжээнд хэрэгжилтийг хангаж ажиллах байгууллага нь ХГБХХГ байна.

Архангай аймгийн хэмжээнд 2019-2023 онд хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээнд нийт 437.5 сая төгрөгийг төсвөөс зарцуулжээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/54 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар аймгийн ХГБХХГ-ыг зохион байгуулалтын 5 нэгжид 23 орон тоотойгоор баталсан бөгөөд 2023 оны байдлаар 22 орон тоотойгоор ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4², 20 дугаар зүйлийн 20.1³-д заасны дагуу “Хамтарсан баг” -ийг байгуулсан бөгөөд 19 суманд нийт 153 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хамтарсан баг нь хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах үүрэгтэй бөгөөд хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Хамтарсан баг нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн яаралтай үед нэн

¹ хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах;

² Хамтарсан баг гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр гэж ойлгоно.

³ Хамтарсан баг нь өрхийн эмч, сум болон хорооны нийгмийн ажилтан, сургуулийн, нийгмийн халамжийн болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, баг, хорооны Засаг дарга ахална.



даруй, бусад нөхцөлд 72 цагт багтаан төлөвлөж, хууль журамд заагдсан хариу үйлчилгээг үзүүлж иржээ.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд шуурхай тусламжийн үйлчилгээнд 78 хүүхэд, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 5954 хүүхэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 37470 хүүхдэд, нийт 43502 хүүхдэд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлсэн байна.

БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ АЖИЛЛААГҮЙГЭЭС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭЭГҮЙ БАЙНА.

Аудитын асуудлын шинжилгээний 1.1.1-1.1.3, 1.1.5 дахь асуултын хүрээнд аймаг дахь Төрийн аудитын газраас горим сорил хэрэгжүүлээгүй болно.

1.1 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦОО НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХИЙГ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮНЭЛЖ, ДҮГНЭЭГҮЙ БАЙНА.

Аудитын явцад аймгийн ХГБХХГ болон аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс тодруулга авахад “Хүүхэд хамгааллын бодлого тогтолцоо нь Нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлж, дүгнэж байгаагүй” гэсэн хариултыг өгсөн болно.

1.1.4 АЙМГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛААГҮЙ БАЙНА.

“Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталж, хөтөлбөрийн 1.2-д “Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал”-ын чиглэлээр 3 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь “Алсын хараа-2050”-ийн “Хүний хөгжил” хоёрдугаар бүлгийн Зорилго 2⁴, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.8⁵-д заасантай уялдсан байна. Үүнд:

- 1.2.6 Хуримтлалтай хүүхэд арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгох, мэдлэг олгох сургалт сурталчилгааг тогтмолжуулна.
- 1.2.7 Хүүхэд залуучууд, гэр бүлд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, дарамт мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулахад орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага болон ТББ, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.
- 1.2.8 Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил, хөдөлмөр эрхлэх, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлогын уялдуулан хэрэгжүүлнэ.

⁴ Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг бэхжүүлнэ.

⁵ Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.



Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан Аймгийн ИТХ-аас жил бүр баталсан аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тусган баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-1 аймгийн хөгжлийн
төлөвлөгөөний арга хэмжээний тоо

Д/д	Он	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо	Аймгийн ИТХ-ын тогтоолын дугаар, он, сар өдөр
1.	2019	4	2018.11.30 №07
2.	2020	2	2019.11.02 №07
3.	2021	2	2020.12.03 №06
4.	2022	4	2021.12.02 №12
5.	2023	5	2022.11.30 №08
Нийт		17	

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/75 дугаар захирамжаар "Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм"-ийг, 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/163 дугаар захирамжаар хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ.

 Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг" шинэчлэгдэн батлагдсан бөгөөд **2019-2023 онд Архангай аймаг нь Хүүхэд хамгааллын талаар баримлах бодлогын баримт бичгийг шинэчлэн батлаагүй**, аймгийн ИТХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 75 дугаар тогтоолоор баталсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1⁶, 16.4.1⁷-т заасантай нийцэхгүй байх тул аудитаас бодлогын баримт бичгийг шинэчлэн батлах зөвлөмжийг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албанд хүргүүлээ.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн хавсралтаар зөвлөлийн гишүүдийн чиг үүрэгт "Хүүхдийн эрх зөрчигдөх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх асуудлаар бодлого зохицуулалтыг хийх, салбар дундын болон төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах" ажлыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцсан байна.

 2019-2023 оны хооронд Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс нь аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэмд заасан "Хүүхдийн эрх зөрчигдөх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх асуудлаар бодлого зохицуулалтыг хийх, салбар дундын болон төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах" чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байх тул аудитаас зөвлөмж хүргүүлээ.

⁶ тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

⁷ хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах;



1.1.6 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ХӨТӨЛБӨР НЬ ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД АМЬДАРЧ БАЙГАА, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БОЛОН ДОТУУР БАЙРАНД АМЬДАРЧ БАЙГАА ХҮҮХДҮҮДЭД ЧИГЛЭСЭН БАЙНА.

Архангай аймагт 2023 оны байдлаар нийт 36,387 мянган хүүхэд/ Аймгийн Статистикийн хэлтсийн хүн амын тоо мэдээгээр/ амьдарч байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд 517, хөгжлийн бэрхшээлтэй 481, дотуур байранд амьдарч буй 2019, Хурдан морины уралдаанч 1581, Сургууль завсардсан 28 хүүхэд байгаа гэсэн мэдээг аймгийн ХГБХХГ-аас гаргажээ.

Дүрслэл-1 Аймгийн нийт хүүхдийн тоон мэдээлэл



Эх сурвалж: Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын статистик мэдээ

Аймгийн Засаг даргын А/54 дүгээр захирамжаар 2022 онд “Хүүхэд хөгжил-Архангай” арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэж, энэхүү арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✚ 2022-2023 оны хичээлийн жилд ЕБС-д суралцаж буй 151, СӨБ-д суралцаж буй 27 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан байна.
- ✚ Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүд 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд Цэцэрлэг, Тариат суманд ажиллаж нийт 35 хүүхдийг боловсролд хамруулах, эцэг эхэд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулжээ.
- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх аргачлал зөвлөмжийг сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт тогтмол өгч арга зүйд сургах сургалтыг зохион байгуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тухайд:

Архангай аймагт 2019-2023 онд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 26-62 хувь нь сургууль цэцэрлэгт хамрагдсан байна.



Хүснэгт-2 2019-2023 оны Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль цэцэрлэгт хамрагдалт

ДД	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	262	375	403	244	481
2	Сургууль, цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	120	137	104	150	298
3	Сургууль цэцэрлэгт хамрагдалтын хувь	46 %	37 %	26%	61%	62%

Эх сурвалж: Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын статистик мэдээ Дотуур байранд суралцаж буй хүүхдүүдийн тухайд:

Архангай аймгийн хэмжээнд сургуулийн дотуур байранд 2019 онд 1933, 2020 онд 1806, 2021 онд 2175, 2022 онд 2041, 2023 онд 2019 сурагч суралцсан статистик тоо гарчээ.

Хүснэгт-3 Архангай аймгийн 2019-2023 оны Дотуур байрны сурагчдын тоон үзүүлэлт

Д/д	Сонгосон үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо	1933	1806	2175	2041	2019

Эх сурвалж: Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын статистик мэдээ

2023 онд Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд аймгийн 6 суманд “Дотуур байрны хүүхдээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээнд 560 гаруй хүүхэд хамрагдсан байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тухайд:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-т "эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ" гэж заасан байдаг.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар нийт 517 хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа гэсэн мэдээтэй байна.

Дүрслэл-2 Аймгийн эрсдэлт нөхцөлд байгаа нийт хүүхдийн тоон мэдээлэл



Эх сурвалж: Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын статистик мэдээ



Хурдан морины уралдаанч хүүхдийн тухайд:

Архангай аймгийн хэмжээнд 2019-2023 онд хурдан морины 57 удаагийн уралдаанд давхардсан тоогоор 1890 уралдаанч хүүхэд оролцож, уралдаанд оролцсон хүүхдүүдээс 99 хүүхэд буюу 2 хувь нь мориноос унаснаас 28 хүүхэд буюу 28.3 хувь нь хөнгөн гэмтэл авсан, 3 хүүхэд буюу 3 хувь нь хүнд бэртэл авч, 1 хүүхэд сурах хөгжих чадвараа бүрэн алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон, 2 хүүхэд уралдаанаас болж нас барсан мэдээтэй байхад Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын Ерөнхий газар болон Аймгийн ХГБХХГ-ын статистик мэдээнд 2021 онд нас барсан 1, хөгжлийн бэрхшээлтэй болсон 1 нийт эрх нь зөрчигдсөн 2 хүүхдийн мэдээллийг тусгаагүй байна.

Хүснэгт-3 Архангай аймгийн хэмжээний 2019-2023 оны хурдан морины уралдаанч хүүхдүүдийн тоон үзүүлэлт

Д/д	Он	Нийт уралдаанч хүүхдийн тоо	Мориноос унасан хүүхдийн тоо				Нийт мориноос унасан хүүхдийн тоо
			Бэртэлгүй хүүхдийн тоо	Бэртэж гэмтсэн хүүхдийн тоо		Нас барсан	
				Хөнгөн	Хүнд		
1	2019	216	14	2			16
2	2020	578	-	5			5
3	2021	-	-	-			-
4	2022	376	-	13	3	2*	19
5	2023	720	53	8			61
Нийт дүн		1890	67	28	3	2	95

Уралдаанч хүүхдийн эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалах, хурдан морины уралдаан зохион байгуулалтыг сайжруулах, хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй уралдааныг хориглон, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын хяналт, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа хэдий ч хүүхдийн эрхийн зөрчил буурахгүй байгаад асуудлын шинжилгээний 3.2.5-д Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт албан шаардлагыг хүргүүлээ.



Жилийн ажлын хүрээнд 2 зорилт, 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн ажлын хүрээнд:

✚ “Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлэн 6 багийн 48 эрсдэлт өрхийн 284 хүүхдийг илрүүлж, 180 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.

✚ “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран Өлзийт, Хайрхан, Өгийнуур суманд сэтгэл зүйч ажиллуулан 9 хүүхдэд ганцаарчилсан, 30 хүүхдэд

бүлгээр зөвлөгөө өгч, сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр Монгол уламжлал, ёс заншил, малчдын ахуй амьдралтай танилцуулах, багаар ажиллах, бие даах чадварыг хөгжүүлэх, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхдийн хөдөлмөр зуслан” хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.



1.2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭРГЭЖИЛТНИЙ ЖИШИГ НОРМАТИВГҮЙГЭЭС ХҮНИЙ НӨӨЦ ХҮРТЭЭМЖГҮЙ, БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Асуудлын шинжилгээний 1.2.1 дахь асуулт нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой тул орон нутагт үнэлээгүй болно.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд болох аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, аймгийн ХГБХХГ, хамтарсан багийн 2019-2023 оны ажлын хоорондын уялдааг аудитаар авч үзлээ.

1.2.2. АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ, ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРОО, АЙМГИЙН ХГБХХГ-ЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн тухайд:

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Хүүхдийн эрхийг хангах талаарх салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.1-д заасны дагуу хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээг авах ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх замаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/75 дугаар захирамжаар "Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм"-ийг, 2022 оны А/163 дугаар захирамжаар хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ.

Тус зөвлөл нь 2020-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвлөлийн тэргүүнээр батлуулж ажилласан ба 2020 онд 2 зорилт, 21 арга хэмжээг төлөвлөж, 2021 онд 2 зорилт, 52 арга хэмжээг төлөвлөж, 2022 онд 2 зорилт, 35 арга хэмжээг төлөвлөж, 2023 онд 17 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг тайлагнасан боловч төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй байна. Энэ нь Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 2.12⁸, 2.13⁹ дахь заалтыг зөрчиж байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 3.2-т заасны дагуу хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх үүрэгтэй ба 2021 онд 01/372 дугаар албан бичгээр төрийн

⁸ Зөвлөл нь жилд 1 удаа /бүтэн жилээр/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд ажлаа тайлагнана.

⁹ Зөвлөл нь жилийн ажлын тайлангаа нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, түүний ажлын алба Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХХГ-т хүргүүлнэ.



байгууллагуудад 19 заалт бүхий чиглэл, 2022 онд 01/466 дугаар албан бичгээр 21 заалт бүхий чиглэлийг хүргүүлсэн боловч аймгийн ХГБХХГ нь чиглэлийн дагуу хэрэгжилтийг үнэлж ажиллаагүй байна. Хүүхдийн төлөө зөвлөлөөс 2019, 2020, 2023 онуудад холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх үүргийг хэрэгжүүлээгүй байна.



Аудитаас аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Аймгийн хүүхэд эрхийн хууль зүйн хорооны тухайд:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15.1-д заасны дагуу Аймгийн Засаг даргын 2022 оны А/15 дугаар захирамжаар аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 15 гишүүнтэйгээр шинэчлэн баталжээ.

2019-2023 онуудад аймгийн Хүүхдийн эрхийн Хууль зүйн хороо нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40.8¹, 41.3¹, 48.1¹-т заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- ✓ 2019-2023 онд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлээгүй.
- ✓ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдээс 2019-2021, 2023 онуудад Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг авч ажиллаагүй байна.



Аудитаас ХЭХЗХ-ны ажлын алба болох аймгийн ХГБХХГ-т албан шаардлага хүргүүлээ.

Сум хорооны хамтарсан багийн тухайд:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Аймаг, сум, нийслэл дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 18.1.5.сум, хороонд хамтарсан баг байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих*” гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹⁰, 20 дугаар зүйлийн 20.1¹¹-д заасны дагуу “Хамтарсан баг” -ийг байгуулсан бөгөөд 19 суманд нийт 153 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хамтарсан баг нь хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах үүрэгтэй бөгөөд хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Хамтарсан баг нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн яаралтай үед нэн даруй, бусад нөхцөлд 72 цагт багтаан төлөвлөж, хууль журамд заагдсан хариу үйлчилгээг үзүүлж иржээ.

¹⁰ “Хамтарсан баг” гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр гэж ойлгоно.

¹¹ Хамтарсан баг нь өрхийн эмч, сум болон хорооны нийгмийн ажилтан, сургуулийн, нийгмийн халамжийн болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, баг, хорооны Засаг дарга ахална.



1.2.5 АЙМГИЙН ХГБХХГ НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭГ ЕРӨНХИЙ ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭН НЭГТГҮҮЛДЭГ БОЛОВЧ НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНГҮЙ БАЙНА

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 01/429 дүгээр албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу эйбл софт хэрэглээний программд суурилсан хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сангийн “Тохиргоо” цэсийн мэдээлэл авах хэсэгт хүүхэд хамгааллын чиглэлээр “Хурдан морины уралдаан”, “Асрамж, халамжийн төв”, “Хүүхэд харах үйлчилгээ”, “Хүүхдийн зуслан”, “Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн бүртгэл” зэрэг 5 төрлийн мэдээллийг нэгтгэж байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооны даргын 2015 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлт тооцох аргачлал”, Хүүхдийн төлөө Үндэсний газрын даргын 2016 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан маягт, Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээний тоон мэдээ авах маягт батлах тухай” маягтын дагуу 2019-2023 оны статистик мэдээг аймгийн ХГБХХГ нь ХГБХХЕГ-т хүргүүлсэн боловч тоон мэдээг албажуулан хадгаламжийн нэгж болгоогүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын хүргүүлсэн тоон мэдээг гүйцэтгэлийн тайланд тусгагдсан тоон, мэдээ, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн бүртгэлийн able программын мэдээ, 108 утасны childrenhelpline программын мэдээтэй тулгахад зөрүүтэй байна. /Нотлох баримт 5-д хавсаргав/.

Аймгийн ХГБХХГ нь тоон мэдээг аргачлал, маягтын дагуу гаргадаг боловч хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан, хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын “нэгдсэн” сангуй байна.

 Аудитаас дээрх зөрчил дутагдлыг арилган статистик тоон мэдээг үнэн зөв бүртгэх, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сантай болох зөвлөмжийг аймгийн ХГБХХГ-т хүргүүллээ.

1.2.6 АЙМГИЙН ХГБХХГ НЬ БАТЛАГДСАН ОРОН ТООНЫ ДАГУУ АЖИЛЛАЖ БАЙГАА ХЭДИЙ Ч, ХГБХХЕГ-ААС ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭРГЭЖИЛТНИЙ ОРОН ТООНЫ ЖИШИГ НОРМАТИВЫГ БАТЛААГҮЙ БАЙНА.

Аймгийн Засаг даргын захирамжаар “Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дүрэм, бүтэц, орон тоо”-г 2 удаа шинэчлэн баталсан байна.Үүнд:

- 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/257 дугаар захирамжаар зохион байгуулалтын 3 нэгжид 17 орон тоотойгоор баталсан.
- 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/146 дугаар захирамжаар зохион байгуулалтын 4 нэгжид 22 орон тоотойгоор баталсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/54 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар зохион байгуулалтын 5 нэгжид 23 орон тоотойгоор баталсан байна.



Аймгийн ХГБХХГ-т 2019-2023 оны байдлаар 37 албан хаагч буюу дунджаар 33 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн, 40 албан хаагч буюу дунджаар 36 хувь нь шинээр томилогджээ. 2019 онд 5 ажилтнаар, 2020 онд 2 ажилтнаар батлагдсан орон тооноос илүү ажиллаж, 2021-2023 онд батлагдсан орон тоонд багтаж ажилласан байна. Албан хаагчдын мэргэжил, ажилласан жилийг авч үзэхэд дунджаар нийт албан хаагчдын 28.6 хувь нь нийгмийн ажилтан, 15.2 хувь нь сэтгэл зүйч мэргэжилтэй бол 56.2 хувь нь бусад төрлийн мэргэжилтэй, дунджаар 1 жил хүртэл ажилласан 3, 2-3 жил ажилласан 4, 4-5 жил ажилласан 4, 5-аас дээш жил ажилласан 10 албан хаагч байна. Тус газар нь 2019-2022 оны хооронд хүүхдийн эрхийн 2 улсын байцаагчтайгаар үйл ажиллагаа явуулж, 2023 онд ажил гүйцэтгэх гэрээгээр 1 улсын байцаагчийг ажиллуулсан байна. Аймгийн ХГБХХГ-ын хүний нөөц тогтвортой боловч нийт албан хаагчдын 43.8 хувь нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч мэргэжилтэй байна.

Дүрслэл-3 Аймгийн ХГБХХГ-ын ажилчдын мэдээлэл




Тус газрын Хүүхэд хөгжил, хамгааллын нэгж нь хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, хүүхдийн эрхийн улсын байцаагч 1, хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн 1, хүүхдийн эрх хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн 1 гэсэн нийт 4 орон тоотойгоор батлагдсан орон тооны дагуу ажиллажээ.

Аймгийн 19 сумын хамтарсан багийн гишүүдийн хүний нөөцийн чадавхыг 153 гишүүдийн ажилласан жилээр харуулбал:

Хамтарсан багийн нийгмийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй байна. Энэ нь нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт нь тодорхой бус, ажлын ачааллыг бүрэн тооцдоггүй, цалин бага, ажлын байрны тодорхойлолтод зааснаас илүү ажлыг дайчлан хийлгэдэг зэрэгтэй холбоотой талаар уулзалтын явцад тайлбарлаж байсан. Архангай аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар хамтарсан багт 23 нийгмийн ажилтнаар ажиллаж байгаагаас 8 буюу 34.7 хувь нь мэргэжлийн, 15 буюу 65.3 хувь нь улс төр судлаач, эдийн засагч, гадаад харилцааны зэрэг мэргэжилтэй байна.

Дүрслэл-4 Хамтарсан багийн ажилчдын мэдээлэл



Уламжлах санал: Хүүхэд хамгааллын мэргэжилтний орон тооны жишиг нормативыг тухайн орон нутгийн хүүхдийн тоотой уялдуулан батлуулах саналыг ХГБХХГ-т УАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛААР БАТЛААГҮЙ БАЙНА



2.1.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ ТӨСВИЙН ТӨСӨЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ БАЙНА

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын зардлыг 2019 оны төсвийн төсөлд төлөвлөж тусгаагүй, 2020-2022 онд өмнөх оны зардлын гүйцэтгэлийг 10-15 хувиар өсгөн төсөвлөсөн харин 2023 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23/27 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэн төсөв, зардлыг төлөвлөсөн байна.

2019-2023 оны хүүхэд хамгааллын зардлын төсвийн төсөл, батлагдсан төсөв

Хүснэгт-4 Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны төсвийн төсөл /мянган төгрөгөөр/

Тайлан т он	2019 он		2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв
Хүүхэд хамгааллын зардал	-	73,90 0.0	145,546.3	93,512. 4	119,600 .0	68,000. 0	119,600 .0	74,018 .2	145,308 .7	108,09 0.1

Аймгийн ХГБХХГ нь “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэн аймгийн хүүхэд хамгааллын 2023 оны төсвийн төслийг дараах ангиллаар нийт 145,308.7 мянган төгрөгөөр төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 108,090.1 мянган төгрөгөөр эцэслэн баталжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-5 Аймгийн ХГБХХГ-ын 2023 оны төсвийн төсөл /мянган төгрөгөөр/

ДД	Ангилал	2023 он		Зөрүү
		Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	
1	Шуурхай тусламж /80236/	4,263.0	1,411.9	2,851.1
2	Хамгаалах, нөхөн сэргээх/80237/	70,277.7	62,126.0	8,151.7
3	Урьдчилан сэргийлэх//	70,768.0	44,552.2	26,215.8
Нийт дүн		145,308.7	108,090.1	37,218.6

Хүүхдэд зориулагдсан сургалт, хөгжил буюу урьдчилан сэргийлэх үйлчилгээнд нийт төсвийн 41.2 хувь болох 44,552.2 мянган төгрөг, хариу үйлчилгээ буюу шуурхай тусламжийн үйлчилгээнд 1.3 хувь буюу 1,411.9 мянган төгрөг, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 57.5 хувь болох 62,126.0 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан байна.

Уламжлах санал: Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд төсвийн төслийг /хүснэгт 4/-д зааснаар хүргүүлсэн боловч **ХГБХХЕГ-аас төсвийн төсөлд үндэслэн төсвийг батлаагүй** байгаад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах саналыг ХГБХХЕГ-т ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.



2.1.2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАТЛАГДСАН ЗАРДЛЫН 55.4 ХУВЬ НЬ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАГДАЖ БАЙГАА ХЭДИЙ Ч ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ БУУРААГҮЙ БАЙНА.

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д “төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн ... санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасан байна.

Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны төсвийг үндсэн чиг үүрэгт хамаарах нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, гэр бүлийн хөгжил, хамгааллын төсвийг зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр “Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал” гэсэн эдийн засгийн ангилалд нийт дүнгээр баталсан байна.

Урьдчилан сэргийлэх сургалт арга хэмжээний тоо, зардлын дүн ба хүүхэд холбогдсон гэмт хэргийн тоог харьцуулсан судалгаа

Хүснэгт-6
/мянган төгрөгөөр/

ДД	Он	Сургалт арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	108 утасны дуудлага мэдээллийн тоо	Бэлгийн хүчирхийллийн тоо
1	2019	15	46,864.3	60	4
2	2020	30	30,188.5	76	8
3	2021	41	64,070.6	101	5
4	2022	40	49,640.8	111	9
5	2023	27	51,447.3	115	8
Нийт дүн		153	242,211.5	463	34

2023 оны хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийн тоог 2019 онтой харьцуулахад 55 дуудлагаар буюу 53 хувиар, ХГБХХЕГ-аас ирүүлсэн 2023 оны насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн тоог 2019 онтой харьцуулахад 4 хэргээр буюу 50 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн ХГБХХГ нь урьдчилан сэргийлэх чиглэлээр 2019-2023 онуудад 242,211.5 мянган төгрөгийн 153 арга хэмжээ зохион байгуулсан хэдий ч хүүхэд холбогдсон гэмт хэргийн тоо болон хүчирхийлэлд өртсөн дуудлага мэдээлэл буураагүй байна.

2.1.3 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ОРОН НУТГААС САНХҮҮЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт, нөөцийг 2023 он хүртэл тооцох аргачлалгүй байсан тул шаардлагатай нөөцийг тодорхойлох, зардлыг тооцох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлээгүй байна.

Харин 2023 оны төсвийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23/27 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал”-ын 2 дугаар хавсралтаар баталсан нормативын дагуу цалин урамшуулал, бичиг хэрэг, бичиг баримтжуулах, холбон



зуучлах гэсэн зардлын төрлөөр тооцсон байна. Гэвч аймгийн ХГБХХГ-ын 2023 оны төсвийг ХГБХХЕГ-аас энэхүү тооцсон дүнгээс бууруулан баталж хуваарилсан байна.

Хүүхэд хамгааллын зардлын 2019-2023 оны батлагдсан төсвийн мэдээлэл

Хүснэгт-7 2019-2023 оны батлагдсан төсөв

Тайлант он	Батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/				
	2019	2020	2021	2022	2023
Хүүхэд хамгааллын зардал	73,900.0	93,512.4	68,000.0	74,018.2	108,090.1

Жил бүр хүүхэд хамгааллын төсвийг нэмэгдүүлэн баталж байгаа боловч хүүхдийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой статистик мэдээнээс үзэхэд сүүлийн жилүүдэд зөрчлийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь хүүхэд хүчирхийлэлд өртсөний дараа бус хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг эрт илрүүлэх үйл ажиллагаанд төсвийг илүү хуваарилах хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

Аймгийн ХГБХХГ-ын дэргэдэх түр хамгаалах байрны урсгал зардлын санхүүжилтийг 2019-2023 онд орон нутгийн төсөвт тусган батлуулаагүй нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын заалттай нийцэхгүй байна.

Түр хамгаалах байрыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 18 дугаар тогтоолоор тус газрын дэргэд байгуулсан ба барилга байгууламжийг "Жерес" Олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 2018 онд барьж ашиглалтад оруулжээ. Түр хамгаалах байр нь одоогоор 3 нийгмийн ажилтны орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

 Аудитаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4¹², Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар баталсан "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2¹³-т заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

2.2. ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙГ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛЖ, ИЛ ТОД ТАЙЛАГНАСАН БАЙНА.

2.2.1 АЙМГИЙН ХГБХХГ НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд хүүхэд хамгааллын чиглэлээр Улсын төсвөөс 417,521.0 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-8 Хүүхэд хамгааллын зардлын санхүүжилтийн эх үүсвэр /мянган төгрөг/

ДД	Он	Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн
----	----	-------------------------	------------

¹² орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

¹³ Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлын төсвийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь жил бүр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төсөвлөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.3-т заасан хугацаанд тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ



		Улсын төсвөөс	Орон нутгаас	
1	2019	73,900.0	-	73,900.0
2	2020	93,512.4		93,512.4
2	2021	68,000.0	20,000.0	68,000.0
3	2022	74,018.2		74,018.2
5	2023	108,090.1		108,090.1
Нийт дүн		417,521.0	20,000.0	437,520.7

Аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны хүүхэд хамгааллын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримт, материалтай тулган баталгаажуулахад 10,335.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-9 Аймгийн ХГБХХГ-ын зориулалт бус зардал /мянган төгрөгөөр/

ДД	Зардлын ангилал	Мөнгөн дүн	Шийвдэрийн дугаар
1	Зорилтот гэр бүлд дэмжлэг/гэр/	2,900.00	Газрын даргын 2020 оны А/83
2	ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны сургалт	2,700.00	Газрын даргын 2021 оны А/83
3	Л. Уранчимэгийн "Бариа", "Хүслэн" зохиолыг дэлгэцийн бүтээл болгох.	1,200.00	Газрын даргын 2021 оны А/44, А/69
4	Залуучуудад цахим үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулах, Залуучуудын орчныг сайжруулах	2,258.90	Газрын даргын 2021 оны А/55, А/56
5	Ахмад настанд дэмжлэг үзүүлэх	1,276.40	-
Нийт дүн		10,335.30	-

Хүүхдийн хөгжил хамгааллын зардлаас 2019-2023 онд эрсдэлт нөхцөлд орсон хүүхэд, гэр бүлд 64,163.1 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Уг дэмжлэгээс 156 хүүхдэд үзүүлсэн 18,720.2 мянган төгрөгийг түүвэрлэн эрсдэлийн программ руу тулгалт хийхэд 140 хүүхэд буюу 89.7 хувь нь программд бүртгэлгүй, дэмжлэг үзүүлсэн хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн анхан шатны баримтгүй байлаа.



Хүүхэд хамгааллын зардлаас 10,335.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹⁴-т заасантай нийцэхгүй байгаад албан шаардлага, Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд 2019-2023 онд үзүүлсэн дэмжлэгийг түүвэрлэн эрсдэлийн программ руу тулгалт хийхэд 140 хүүхэд буюу 89.7 хувь нь эрсдэлийн able программд бүртгэлгүй, нөхцөл байдлын үнэлгээ хийсэн анхан шатны баримтгүй байна. Энэ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн

¹⁴ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах



сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/120, А/178 дугаар тушаалын "Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам"-ын 1.4¹⁵, 2.19¹⁶-т заасантай нийцэхгүй байх тул зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн ХГБХХГ-т хүргүүлээ.

2.2.2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТЫГ ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН СИСТЕМ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ВЕБ ХУУДСАНД НЭЭЛТТЭЙГЭЭР МЭДЭЭЛЖ БАЙНА.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг шилэн данс болон байгууллагын пэйж хуудсанд нээлттэйгээр мэдээлсэн байна.

Төрийн аудитын газраас 2019-2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагааг фейсбүүк /facebook/ хуудас болон вэб хуудсаар нээлттэйгээр мэдээлсэн байна.

2.2.3 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ОЛОН УЛСЫН ДОНОР БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

НҮБ-ын санхүүжилтээр нийт 98,110.0 мянган төгрөгийн "Гэрэлт ирээдүй" төслийг хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд:

- ✚ **2021 онд** "Гэрэлт ирээдүй" төслийн хүрээнд 17,855.0 мянган төгрөгийн санхүүжилт авч аймгийн ХГБХХГ-ын Түр хамгаалах байранд оёдлын тоног төхөөрөм, Хүүхдийн тамир зусланд талх нарийн боовны тоног төхөөрөмж авч тохижуулсан.
- ✚ **2022 онд** "Гэрэлт ирээдүй" төслийн хүрээнд 80,255.0 мянган төгрөгийн санхүүжилт авч аймгийн ХГБХХГ-ын Түр хамгаалах байранд 64,042.5 мянган төгрөгөөр **Бага оврын ногооны хүлэмж**, 17,212.5 мянган төгрөгөөр Түр хамгаалах байрны ариун цэврийн өрөөг засварласан байна.

Төсөл хэрэгжүүлэгч 2021, 2022 онд нийт 2 удаа тусламжийн хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн гэх боловч тайлан нь аймгийн ХБГХХГ-т байхгүй.

2.2.4 АЙМГИЙН ХГБХХГ НЬ 2019-2023 ОНД БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛСЭН БАЙНА.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т "Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээг үзүүлнэ" гэж заасан байна. Үүнд:

- Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах,
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх,
- Аюулгүй байдлыг хангах, дэмжих,
- Холбон зуучлах,
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх,

¹⁵ нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, шаардлагатай тохиолдолд аймаг, дүүрэгт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, суманд нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, хамтарсан багийн бусад гишүүнтэй хамтран хийнэ

¹⁶ хамтарсан багийн нарийн бичгийн дарга нөхцөл байдлын үнэлгээний талаарх мэдээллийг холбогдох мэдээллийн санд оруулна



- Гэр бүлд нь эргэн нэгтгэх.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд шуурхай тусламжийн үйлчилгээнд 78 хүүхэд, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 5954 хүүхэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 37470 хүүхдэд, нийт 43502 хүүхдэд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн ХГБХХГ-ын дэргэдэх түр хамгаалах байраар 2019-2023 онд 78 хүүхэд, 26 насанд хүрэгчид үйлчлүүлсэн байна. Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүүхдүүдэд дээр дурдсан 6 үйлчилгээг цогцоор хүргэж ажилласан ба ажиллаж буй албан хаагчдын цалингийн зардалд нийт 141,672.3 мянган төгрөгийг, үйл ажиллагааны зардалд нийт 31,951.9 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-10 Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч болон зардлын тооцоо /мянган төгрөгөөр/

Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчийн тоо		2019	2020	2021	2022	2023	Нийт
ТХ байр	Насанд хүрэгч	5	2	6	8	5	26
	Хүүхэд	17	11	13	13	24	78
Нийт үйлчлүүлэгчийн тоо		22	13	19	21	29	104
Үйл ажиллагааны зардалд		8,508.6	7,002.9	5,013.1	3,407.9	8,019.3	31,951.9
Цалингийн зардалд		16,730.2	23,788.2	27,413.1	27,575.8	46,163.2	141,672.3
Нийт зардал		25,238.8	30,791.1	32,426.2	30,983.7	54,182.5	173,624.2

2.2.5 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮҮХДИЙН ХУВИЙН НУУЦ БҮРЭН ХАМГААЛАГДАХГҮЙ БАЙНА.

Аймгийн ХГБХХГ болон хамтарсан багаас хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ хүүхдийн мэдээллийг задруулахгүй байх, хүүхдийн хувийн нууцтай холбоотой асуудал хэрхэн хамгаалагдаж байгаад хяналт хэрэгжүүлэхэд ХГБХХГ нь 2019-2023 онд албан хаагчдаас албаны нууц задруулахгүй байх баталгааг авч ажиллаагүй байна. Харин хамтарсан багуудын гишүүд нь нууцын баталгаа гарган ажиллаж хэвшсэн байна.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой баримт материал, кейсийг хадгаламжийн нэгж болгоогүй байгаа нь хүүхдийн хувийн нууцыг задруулах эрсдэлтэй байна.

Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудтай уулзалт хийхэд: ..Нийгмийн ажилтан нь хамтарсан багийн гишүүд нууцын баталгаа гаргадаг хэдий ч хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх явцад хүүхдийн мэдээллийг хамтарсан багийн аль нэг гишүүн задруулдаг нь хариу үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй байдаг тухай дурдаж байсан.



Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд албан хаагчдаас албаны нууц задруулахгүй байх баталгааг авч ажиллаагүй, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой баримт материал, кейсийг хадгаламжийн нэгж болгоогүй байгаа нь Хүний хувийн мэдээлэл



хамгаалах тухай хуулийн 2.1.8¹⁷-д заасантай нийцэхгүй байгаад аймгийн ХГБХХГ-т зөвлөмж хүргүүлээ.

2.2.6 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВ УРЬДЧИЛСАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ БОЛОН ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭНД ОНОВЧТОЙ ХУВААРИЛАГДАН ТӨСӨВЛӨГДСӨН БАЙНА.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд шуурхай тусламжийн зардалд 23,789.9 мянган төгрөг, хамгаалах нөхөн сэргээх зардалд 149,608.6 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардалд 262,220.6 мянган төгрөг, нийт 437,520.7 төгрөгийг зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-9 Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалт /мянган төгрөг/

Он	Шуурхай тусламж		Хамгаалах нөхөн сэргээх		Урьдчилан сэргийлэх		Төвлөрүүлэх шилжүүлэг	Нийт мөнгөн дүн
	Хүүхдийн тоо	Мөнгөн дүн	Хүүхдийн тоо	Мөнгөн дүн	Хүүхдийн тоо	Мөнгөн дүн		
2019	17	8,508.6	2065	18,527.1	2400	46,864.3	-	73,900.0
2020	11	7,002.9	1008	48,471.8	5300	38,037.7		93,512.4
2021	13	5,013.1	1260	13,796.8	8000	69,190.1		88,000.0
2022	13	1,853.4	954	6,692.3	11390	63,586.4	1,886.1	74,018.2
2023	24	1,411.9	667	62,120.5	10380	44,542.1	15.6	108,090.1
Нийт дүн	78	23,789.9	5954	149,608.6	37470	262,220.6	1,901.7	437,520.7

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд шуурхай тусламжийн үйлчилгээнд 78 хүүхэд, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 5954 хүүхэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 37470 хүүхдэд, нийт 43502 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1.1 ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ЧИГЛЭГДСЭН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ САЛБАРЫН ОНЦЛОГТ НИЙЦСЭН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, НАРИЙВЧИЛСАН АРГАЧЛАЛТАЙ БОЛОВЧ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ ХАНГАЛТТАЙ ТҮВШИНД ХИЙГЭЭГҮЙ БАЙНА

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны "Хамтарсан багийн үйлчилгээ үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал батлах тухай" А/236 дугаар тушаал, 2020 оны Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны

¹⁷ Хүүхдийн хувийн мэдээллийг хүндэтгэж нууцыг хадгалах



үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлал батлах тухай 240 дүгээр тушаалын хэрэгжилтэд 2019-2021 онд Хяналт шинжилгээ үнэлгээг хийгээгүй байна.

Газрын даргын 2022 оны А/74 дүгээр тушаалаар сумдад явуулын үйлчилгээ үзүүлэн Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажилласан боловч биелэлтийг тооцоогүй байна.



Аймгийн ХГБХХГ нь Хяналт шинжилгээ үнэлгээг 2019, 2020, 2021, 2023 онуудад шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалын дагуу хийгээгүй, 2022 оны хяналт, шинжилгээ үнэлгээг хийсэн боловч зөвлөмж, чиглэлийн биелэлтийг тооцоогүй, ажлын тайлан материалыг хадгаламжийн нэгж болгоогүй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 34.1.12¹⁸, 54.1.1¹⁹-т заасантай нийцэхгүй байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2 ХГБХХГ-НЬ ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БАЙНА.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13.1-д “Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тэргүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ”, 13.1.1-т “хүүхдийн эрхийг хангах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцах” гэж заасан байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын даргын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Нээлттэй хяналт-шалгалт хийх тухай ” А/34, 12 дугаар тушаалын дагуу хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн байна.

3.1.3 АЙМГИЙН ХГБХХГ-НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ЗАСГИЙН ГАЗАРТ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/94 дүгээр албан бичгээр “НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын 5 дугаар тайлан, илтгэлд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг ирүүлэхийг” чиглэл болгосон байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1²⁰-д заасны дагуу аймгийн ГБХЗХГ-аас НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын 5 дугаар тайлан илтгэлд өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг 32 үзүүлэлтээр гаргаж, дунджаар 78 хувийн биелэлтэй тайлагнасан байна.

¹⁸ хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах

¹⁹ аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага өөрийн хариуцсан салбарын хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг дараа оны 2 дугаар сард багтаан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

²⁰ Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу Олон Улсын төрөлжсөн байгууллага (Нэгдсэн Үндэсний Байгууллага, түүний салбар байгууллага)-д Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар үндсэн тайланг заасан хугацаанд төрийн байгууллагаас хүргүүлэх бөгөөд хүүхэд, олон нийт, иргэний нийгмийн оролцоотой гаргана.



3.1.4 АЙМГИЙН ХГБХХГ-Т ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Аудитад хамрагдаж буй 2019-2023 онд Архангай аймагт хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагаас тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байна.

3.1.5 АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ НЬ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина” гэж зохицуулсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/240 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, хоёрдугаар хавсралтаар “Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, гуравдугаар хавсралтаар “Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан байна.

Дээрх аргачлалын дагуу жил бүрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор ХГБХХЕГ-т ирүүлэхийг Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албаны дарга нарт үүрэг болгосон байна.

Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба болох аймгийн ХГБХХГ нь Хүүхдийн эрхийн ажилтны 2019-2023 оны үйл ажиллагаа, аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1²¹-д заасантай нийцэхгүй байгаад аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба болох аймгийн ХГБХХГ-т албан шаардлага хүргүүлээ. /асуудлын шинжилгээний 3.1.1-д заасан асуудалтай нэгтгэж албан шаардлага хүргүүлсэн болно /

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс аймгийн ХГБХХГ-ын жилийн үйл ажиллагааны үзүүлэлтийг он тус бүрээр үнэлэхэд 2019-2023 оны үнэлгээний дундаж 88.1 хувьтай үнэлэгдсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал :

Хүснэгт-11 Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний дүн

ДД	Он	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний дүн
1	2019	85.8
2	2020	87.9
3	2021	85.6
4	2022	85.4
5	2023	95.9
Нийт дүн		88.12

²¹ Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина



Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн үнэлгээ

3.1.6 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ БОДИТОЙ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЧЛАЛГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн зааврыг баталсан бөгөөд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулан мөрдөөгүй байна.

Уламжлах санал: Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал боловсруулан батлуулах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд УАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

3.1.7 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ БОДИТОЙ ҮНЭЛЖ НИЙГЭМД ГАРЧ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй тул нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцох боломжгүй байна.

Иймд Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалд бодлогын хэрэгжилтийн үр дүнд нийгэмд эерэг өөрчлөлт гарсан эсэхийг үнэлэх аргачлал, зааврыг тусган боловсруулж батлуулах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд УАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

3.2. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ХЭДИЙ Ч ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ БУУРААГҮЙ БАЙНА

3.2.1 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ГЭР БҮЛД ЧИГЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ БУУРААГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹-д гэр бүл дэх хүүхэд хамгааллын асуудал, 19 дүгээр зүйлийн 19.1.1¹, 19.1.2¹-т хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны явуулах үйл ажиллагааг зохицуулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.6¹, 26.2.3¹-т гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулахаар тус тус хуульчилжээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3²²-т ажил олгогчийн зүгээс ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхийг заасан бол Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-ийг баталсан байна.

²² Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.



Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд 30 төрлийн сургалт үйл ажиллагаа, 2 аян, 4 удаагийн уулзалт хэлэлцүүлэг, 1 хөтөлбөрийг зохион байгуулж ажилласан байна. Аймгийн хэмжээнд 73 аж ахуйн нэгж, байгууллагад “Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөл”-ийг байгуулан эцэг, эх, хүүхэд, багш сурган хүмүүжүүлэгчид болон хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн хариуцлагыг сайжруулах, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, нөлөөллийн ажлыг жил бүр зохион байгуулж иржээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг жил бүр зохион байгуулснаар далд хэлбэрт байсан гэр бүлийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийн илрүүлэлт нэмэгдсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2019-2023 онд ирсэн гэр бүлийн орчинд үйлдэгдсэн хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой дуудлагын тоог графикаар харуулбал:

Дүрслэл-5 Гэр бүлийн орчинд үйлдэгдсэн 108 утасны дуудлага мэдээлэл



3.2.2 АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР НЬ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого"-ын 8-д Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс нь харьяа нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр бүрийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийж, үр дүн бүхий тайланг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлнэ" гэж заасан байна.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2019-2023 хооронд Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого ямар түвшинд хэрэгжиж байгаад хяналт шинжилгээ үнэлгээ хийснийг нотлох баримтгүй байна.



Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2019-2023 онд Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого"-ын 8²³-д заасантай нийцэхгүй байх тул албан шаардлагыг хүргүүлнэ.

²³ Аймаг, нийслэлийн боловсролын газар, сум дүүргийн боловсролын хэлтэс нь харьяа нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр бүрийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг эцэг эхийн зөвлөлтэй хамтран жил бүр хийж, үр дүн бүхий тайланг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлнэ



3.2.3 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР НЬ ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУД, ИРГЭДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛСЭН БАЙНА

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.”, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ” гэж хуульчилжээ.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2019-2023 онд Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг жил бүр зохион байгуулж, Ерөнхий боловсролын 10 сургуулийн 560 сурагчид, 5 сумын 7 цэцэрлэгийн 389 хүүхэд, 5 сургуулийн 900 хүүхдийг түүвэрлэн авч, бие бялдрын хөгжлийн түвшин, өсөлт, хөгжилт, таргалалтын түвшнийг тодорхойлох тандалт судалгаанд хамруулж, судалгааны дүгнэлт зөвлөмжийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хүргүүлжээ. Мөн дотуур байрны эрүүл ахуй халдвар, хамгааллаар талаар сургуулийн 80 багшийг сургалтад хамруулсан байна.

Тус газраас ирүүлсэн тайланд аймагт Хүүхэд, өсвөр үе, залуучууд, иргэдэд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхээр эрүүл мэндийн 113 байгууллага үйл ажиллагаа явуулж байна гэжээ. Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар эрсдэлт нөхцөлд байгаа 517 хүүхдээс түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 78 хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлжээ. Эрүүл мэндийн газарт Хүүхдийн эрүүл, мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 2019-2023 онд 7 гомдол мэдээлэл ирснийг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-12 ЭМГ-т ирсэн өргөдөл гомдлын мэдээ

№	Он	Өргөдлийн тоо	Өргөдөл гомдлын утга		Шийдвэрлэсэн байдал
1	2019	1	Тусламж холбоотой	үйлчилгээтэй	Сахилгын арга хэмжээ авсан
2	2020	1	Тусламж холбоотой	үйлчилгээтэй	Сахилгын арга хэмжээ авсан
3	2021	1	Үл ойлголцол		Зөвлөмж хүргүүлж, дархлаажуулалтыг хийлгэсэн нөхөн
4	2022	1	Тусламж холбоотой	үйлчилгээтэй	Зөвлөмж хүргүүлсэн
5	2023	1	Тусламж холбоотой	үйлчилгээтэй	Сахилгын арга хэмжээ авсан
		1	Тусламж холбоотой	үйлчилгээтэй	Зөвлөмж хүргүүлж, газар дээр нь хяналт хийсэн
		1	Үл ойлголцол		Зөвлөмж өгч үл ойлголцлыг арилгасан.
	Нийт	7			



3.2.4 АЙМГИЙН ХГБХХГ НЬ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд “Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын харилцааг зохицуулжээ.

Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. *Тухайлбал: ...Хамтдаа хөгжье радиогийн цуврал ярилцлага. "Save family" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 6 удаагийн лайв нэвтрүүлэг, "Бид Архангайн ирээдүй" арга хэмжээний хүрээнд телевизийн нэвтрүүлэг 2, радиогийн ярилцлага 1, Жендерт суурилсан хүчирхийлэл" аяны хүрээнд 50 гаруй постер, "Дээрэлхэлтийн эсрэг үе тэнгийнхний", "Архангайн хүүхдүүд", "Томчуудаас асууя", "Цэцэрлэг хотоороо аялъя", "Охид эмэгтэйчүүдийн эрх" зэрэг 5 хүүхдийн нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэн ажилласан байна.*

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2019-2023 онд цахим орчинд эрх нь зөрчигдсөн 4 дуудлага бүртгэгдсэнийг хүлээн авч, хамтарсан багаар дамжуулан хүүхдийн эрхийн зөрчлийг арилгуулсан байна.

3.2.5 СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР НЬ 2019-2023 ОНД ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ, СОЁЛ, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал, 9¹ дүгээр зүйлд Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгааллын асуудлыг зохицуулжээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.4²⁴-т заасны дагуу ГБХЗХГ, Соёл урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 07-ын өдрийн А/242/А/76 дугаар тушаалаар “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг баталж, журмын 2.1-т “Журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих үүргийг Соёл урлагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан ажиллах бөгөөд холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах” гэж заасан байна.

Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/197 тоот албан бичгээр ирүүлсэн тайлбартаа "2019-2023 онуудад Соёл, урлагийн газар нь хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй"

Аймгийн ХГБХХГ нь соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх үүргийн хүрээнд аймгийн хэмжээнд 2019-2023 онд хурдан морины 57 удаагийн уралдаан зохион байгуулагдсанд давхардсан тоогоор 1890 уралдаанч хүүхэд оролцсон бөгөөд аймгийн ХГБХХГ нь хяналт тавин ажилласан байна. Харин Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2019-

2023 онд олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын чиглэлээр хяналт тавьж ажиллаагүй байна.

²⁴ Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээний үед хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.



Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих үүргийг хэрэгжүүлээгүй байгаа нь ГБХЗХГ, Соёл урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 07-ын өдрийн А/242/А/76 дугаар тушаалаар баталсан “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын 2.1²⁵-т заасантай нийцэхгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

3.2.6 ГАМШИГ, ГАМШГИЙН ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ ХАНГАГДАЖ БАЙНА.

Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор баталсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.9.3-д “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх” талаар хуульчилжээ.

Аймгийн ХГБХХГ нь 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, төлөвлөгөө баталж, 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна.

Гамшиг, онцгой байдлын үед мэргэжлийн анги нь 2022 оны төлөвлөгөөний дагуу эрсдэлт нөхцөлд амьдарч буй 50 өрхөд түргэвчилсэн үнэлгээ хийж, хүүхдийг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд холбон зуучилж, 1140 хүүхдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, хүүхэд гэр бүлд чиглэсэн 380 удаагийн цахим зөвлөмж, 3 төрлийн гарын авлага боловсруулан, түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 128 үйлчлүүлэгчид тусламж, дэмжлэг үзүүлэн ажилласан бөгөөд хүүхдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, хүүхэд гэр бүлд сургалт, нөлөөллийн ажлыг түлхүү үзүүлсэн байна. Аймгийн Онцгой байдал нь хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, онцгой нөхцөл байдлын үед орон нутгийн мэргэжлийн ангийг мэргэжил арга зүй, удирдлагаар ханган ажилладаг байна.

3.3. ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ГЭМТ ХЭРГИЙН СУУРЬ ШАЛТГААНЫГ СУДЛААГҮЙ БАЙНА.

3.3.1 АЙМГИЙН ХГБХХГ НЬ МОНГОЛ УЛС ХҮҮХДИЙН ЭРХИЙН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦОД НЭГДСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 онд Хүүхдийн эрхийн тухай Конвенцыг соёрхон баталсан бөгөөд Монгол Улс нь Хүүхдийн эрхийн тухай Конвенцод 1990 онд нэгдэн орсон бөгөөд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “Хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах” гэж заасан байна.

²⁵ Журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих үүргийг Соёл урлагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан ажиллах бөгөөд холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах



Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд агуулгын хувьд тусган хэрэгжүүлсэн байна.

3.3.2 ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН 108 УТСАНД ИРСЭН ДУУДЛАГА, МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН ЭСЭХИЙГ ДҮГНЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

Монгол Улсын Хүүхдийн Төлөө Үндэсний газраас Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг 2005 онд “Дотно утас 1979” нэртэйгээр анх нээн ажиллуулж эхэлсэн ба олон улсын Хүүхдийн Тусламжийн утасны сүлжээ /Child Helpline International/-д 2006 онд элсэн орж, 2008 онд гишүүнчлэлийн статустай болсон байна.

Хүүхдийн тусламжийн 108 утас нь хүүхдийн эрхийн үндсэн зарчмын дагуу хүүхэд бүр аюулгүй тайван, хүчирхийлэлгүй орчинд амьдрах эрхийг хангах механизмыг бүрдүүлэх зорилго бүхий цогц бодлогын хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, хүүхдийн санаа бодлыг сонсох, тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх, хүүхдийг хөгжүүлэх, хүүхдийн оролцоог хангахад чиглэсэн үйлчилгээний нэгдэл бий болгох үндсэн зорилготой байгуулагджээ.

Хүснэгт-13 Аймгийн ХГБХХГ-ын 108 утасны дуудлага мэдээллийн тоо

	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2023 онд нийт 463 дуудлагыг хүлээн авсан байна. Тухайлбал:					Нийт
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	
Дуудлага	60	76	101	111	115	463
Дуудлагыг төрлөөр нь ангилбал:						
Бие махбодын хүчирхийлэл	21	22	36	18	40	137
Бэлгийн хүчирхийлэл	2	3	2	10	7	24
Үл хайхрах хүчирхийлэл	10	14	13	23	13	73
Сэтгэл санааны хүчирхийлэл	7	16	33	29	38	123
Бусад	20	21	17	25	17	100
Хүүхдийн тоо	57	70	136	158	157	578

Эх сурвалж: Childhelpline систем

Дээрх мэдээллээс үзэхэд жил бүр хүүхдийн эрхийн зөрчил нэмэгдсээр байна. Нөгөө талаас хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулснаар далд хэлбэрт байсан хүүхдийн эрхийн зөрчлийн илрүүлэлт нэмэгдсэнийг харуулж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2.5-д "... хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл явцыг холбогдох журам, зааврын дагуу бүртгэх, баримтжуулах, архивлах, мэдээллийн

Хамтарсан багуудтай уулзалт зохион байгуулахад дэвшүүлсэн асуудал: ... 108 утас /childhelpline/, able программыг ашиглахад хүндрэлтэй байдаг. Аймагт хүүхдийн зан үйлд ажиллах нөхөн сэргээх төв байдаггүй.



санд оруулах", Архив, албан хэрэг, хөтлөлтийн тухай хуулийн 24.1.9-т “..байгууллагын удирдлага архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих үүрэгтэй” гэж заасан байдаг. Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 оны Хүүхдийн тусламжийн 108



Аймгийн ХГБХХГ нь 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 297 тоот албан бичгээр ирүүлсэн тайлбартаа: “..2019- 2023 оны хамтарсан багийн холбогдох баримт материалуудыг хадгалж байсан агуулах руу үерийн ус орсны улмаас устсан ..”

утсанд ирсэн дуудлагын бүртгэл, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой баримт материалыг хадгаламжийн нэгж болгодоггүй, байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад баримт материалыг архивд хүлээн авах талаар тусгаагүй байна. Аудитаар Хүүхдийн тусламжийн 108 утсаны Childhelpline программд нэвтэрч хүүхдийн

мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авсан эсэхийг тулган баталгаажуулахад 2019-2023 оны байдлаар программ ашиглалтын 56.6 хувь нь хангалттай, 43.4 хувь нь хангалтгүй байна.

Аймгийн ХГБХХГ нь тайлант хугацаанд хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн 463 дуудлага, мэдээллийг хүлээн авсан боловч дуудлагын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажилласан талаарх анхан шатны баримт материалыг архивын нэгж болгоогүй, 108 утсаны Childhelpline программд мэдээллийг бүрэн оруулаагүйн улмаас дуудлагын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой 2019-2023 оны анхан шатны баримт бичгийг хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивд хүлээн аваагүй байгаа нь асуудлын шинжилгээний 3.3.3-т давхацсан тул нэгтгэн зөвлөмж хүргүүлсэн болно.

3.3.3 ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД ОРСОН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ СТАНДАРТАД НИЙЦСЭН, ТҮРГЭН ШУУРХАЙ БАЙНА

Аймгийн ХГБХХГ нь 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 298 тоот албан бичгээр ирүүлсэн тайлбартаа: “..түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн кейсийг 2019 оноос хойш он тус бүрээр үдэж хавтасласан. Мөн ХЭХЗХ-ны баримт, хадгаламжийн нэгжүүд нь байгууллагын ХХНЖ-т байхгүй болно.”

Аймгийн ХГБХХГ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.1²⁶-т заасны дагуу 2019-2023 онд эрсдэлт нөхцөл байгаа нийт 4436 хүүхдэд “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам”-ын 4.1²⁷, 5.2²⁸-т заасны дагуу аюулгүй зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нэн даруй шаардлагатай хариу арга хэмжээг авдаг байна. Аймгийн ХГБХХГ-ын дэргэдэх түр хамгаалах байраар 2019-2023 онд нийт 104 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс хүүхэд 78, насанд хүрэгч 26 байна. Түр хамгаалах байранд үзүүлсэн үйлчилгээг хүснэгтээр

харуулбал:

²⁶ Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ.

²⁷ Цагдаагийн албан хаагч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болзошгүй эрсдэлийг “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн маягт, аргачлал”-ын дагуу үнэлэх ба энэ нь хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх үндэслэл болно.

²⁸ Хүүхэд, гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн нийгмийн ажилтан хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг хүүхдийн хувийн хэрэгт хавсаргана.



Хүснэгт-14 Түр хамгаалах байранд үзүүлсэн үйлчилгээ

Д/д	Үйлчилгээний төрөл	Үйлчлүүлэгчийн тоо
1	Нийгмийн ажлын үйлчилгээ	93
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	93
3	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	72
4	Асран халамжлах үйлчилгээ	8
5	Эрх зүйн туслалцаа	5
6	Сэтгэлзүйн үйлчилгээ	67
7	Нийгмийн халамжийн үйлчилгээ	2
8	Боловсролын үйлчилгээ	55
Нийт дүн		395

Аймгийн ХГБХХГ нь Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой 2019-2023 оны анхан шатны баримт бичгийг хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивд хүлээн аваагүй байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2.5²⁹, Архив, албан хэрэг, хөтлөлтийн тухай хуулийн 24.1.9³⁰-д заасантай нийцэхгүй байгаад зөвлөмж,

Түр хамгаалах байр нь 2019-2023 онд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлсэн мэдээллийн санг бүрдүүлээгүй байна. Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21.1.1³¹-д заасантай нийцэхгүй байх тул албан шаардлага хргүүлээ.

3.3.4 ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ГЭМТ ХЭРГИЙН СУУРЬ ШАЛТГААНЫГ СУДЛААГҮЙ БАЙНА

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг гэж “Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах, Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, Хүүхдээр гуйлга гуйлгах, Хүүхэд солих, Хүүхэд худалдах, Хүүхэдтэй хэрцгий харьцах, Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх” гэмт хэргүүдийг ойлгоно.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2023 оны хооронд урьдчилан сэргийлэх 153 удаагийн 274,332.2 сая төгрөгийн сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна. Урьдчилан сэргийлэх сургалт арга хэмжээ нь жил бүр тогтмол биш өөр, өөр арга хэмжээ зохион байгуулж байгаа нь хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулж чадахгүй байна.

Тухайлбал: 2019 онд Гэр бүлийн зөвлөгөөн, Бүсгүйчүүд арга хэмжээ, Хийморьлог эрчүүд зэрэг арга хэмжээнд 15 сургалт арга хэмжээнд 59,684.6 мянга, 2020 онд 30 удаагийн сургалт арга хэмжээнд 49,488.9 мянга, 2021 онд 41 удаагийн сургалт арга хэмжээнд 64,070.6 мянга, 2022 онд 40 удаагийн сургалт арга хэмжээнд 49,640.8 мянга, 2023 онд 27

²⁹ хүүхэд хамгааллын кейс бүрд хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл явцыг холбогдох журам, зааврын дагуу бүртгэх, баримтжуулах, архивлах, мэдээллийн санд оруулах

³⁰ байгууллагын удирдлага архивын баримтын хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавих үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байгаад зөвлөмж

³¹ энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээ энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, энэ хуулийн 38.1.1-д заасан сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ, энэ хуулийн 40, 41 дүгээр зүйлд заасан нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх



удаагийн сургалт арга хэмжээнд 51,447.3 мянган төгрөг зарцуулсан боловч хүүхдийн эрхийн зөрчил буураагүй байна.

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон болон холбогдсон хүүхдийн тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-14 Цагдаагийн газраас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон болон холбогдсон хүүхдийн тоон мэдээллийг

№	Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
1	Гэмт хэргийн улмаас хохирсон	25	19	26	27	27	124
	7 хүртэлх нас	11	4	7	6	7	35
	8-13 нас	7	6	10	12	8	43
	14-17 нас	7	9	9	9	12	46
2	Гэмт хэрэгт холбогдсон	8	24	15	48	15	110
	15 хүртэлх нас	2	0	3	31	6	42
	16-17 нас	6	24	12	17	9	68
3	Зөрчилд холбогдсон	2	3	3	6	18	32
	16-17 нас	2	3	3	6	18	32
4	Зөрчлийн улмаас хохирсон	3	9	8	6	19	124
	7 хүртэлх нас	0	0	1	1	2	35
	8-13 нас	2	5	3	1	5	43
	14-17 нас	1	4	4	4	12	46

Эх сурвалж: аймгийн Цагдаагийн газар

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1.7-д “төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хамтарсан багийн ажиллах журам”-ын 5.4-т “Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг орон нутгийн салбар зөвлөл санхүүжүүлж болно” гэсний хүрээнд Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2021-2023 онд 25,400.0 мянган төгрөгийн 75 удаагийн сургалт зохион байгуулагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулвал:

Хүснэгт-15 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс гарсан сургалтын мөнгөн дүн, тоо

Д/д	Он	Сургалтын тоо	Мөнгөн дүн
1	2019	-	-
2	2020	-	-
3	2021	25	7,800.0
4	2022	25	7,800.0
5	2023	25	9,800.0
Нийт дүн		75	25,400.0



3.3.5 САЛБАР БҮР ХҮҮХЭД ХАМГААЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭГ БАТАЛСАН МАЯГТЫН ДАГУУ ГАРГАЖ БАЙГАА БОЛОВЧ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ БАЙНА

Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолтыг олон улсын арга зүйтэй нийцүүлэх, бүх түвшний хэрэглэгчдийг нэгдсэн арга зүй, тоон мэдээллээр хангах зорилгоор Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/145 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг баталсан байна. Аймгийн ХГБХХГ нь дээрх мэдээний маягтын дагуу мэдээний нэгтгэлийг гаргадаг боловч тоон мэдээлэл зөрүүтэй тухай тайлангийн 1.2.5-д дэлгэрэнгүй дурдсан ба сайжруулах арга хэмжээ авах зөвлөмж хүргүүлсэн. Салбар бүр хүүхэд хамгаалалтай холбоотой тоон мэдээг өөрийн салбарын онцлогт тохирсон маягтын дагуу гаргаж байна. Тухайлбал аймгийн ХГБХХГ, ХЭХЗХ, ШШГГ, Цагдаагийн газраас ирүүлсэн тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал

Хүснэгт-16 Аймгийн эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн тоон мэдээлэл

	Аймгийн ХГБХХГ	Хүүхдийн эрхийн Хууль зүйн хороо	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Аймгийн Цагдаагийн газар			Аймгийн Шүүхийн Тамгын газар		
	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээлэл	Үйлчилгээ үзүүлсэн мэдээлэл	ХЧААХ авагдсан хүүхдийн мэдээлэл	Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн мэдээлэл	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн мэдээлэл	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээлэл	Гэрч хүүхдийн мэдээлэл	Хохирогч хүүхдийн мэдээлэл	Шүүгдэгч хүүхдийн мэдээлэл
2019	1164	22	56	28	10	0	22	6	12
2020	1263	27	2	28	27	0	14	17	3
2021	1336	16	3	34	18	148	35	19	10
2022	156	26	5	33	54	44	39	15	12
2023	517	43	0	46	33	20	19	8	3
Нийт	4436	134	66	169	142	212	129	65	40

Эх сурвалж: аймгийн ХГБХХГ, ХЭХЗХ, ШШГГ, Цагдаагийн газар, ШТГ



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг аймгийн хэмжээнд үнэлж, дүгнээгүй байна.
2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага хүүхэд хамгааллын мэргэжилтний жишиг нормативгүйгээс хүний нөөц хүртээмжгүй, бусад байгууллагуудтай харилцан уялдаатай ажиллаагүй байна.
3. Хүүхэд хамгааллын санхүүжилтийг хүртээмжтэй байдлаар батлаагүй байна.
4. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийг батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулж, ил тод тайлагнасан байна.
5. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо хангалтгүй байна.
6. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хэдий ч хүүхдийн эрхийн зөрчил буураагүй байна.
7. Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэмт хэргийн суурь шалтгааныг судлаагүй байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт 10,335.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,335.3 мянган төгрөгийн 8 албан шаардлага, 7 зөвлөмжийг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт хүргүүллээ.

Аудитын тайлангаар Үндэсний аудитын газраар уламжлуулан Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газарт 3 саналыг хүргүүлж байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Б.Цэрэннадмидад

1. Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг"-ийн дагуу аймгийн Хүүхэд хамгааллын бодлогыг шинэчлэн батлах
2. Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан олон нийтэд мэдээлэх
3. Аймгийн ХГБХХГ-ын дэргэдэх Түр байрлуулан хамгаалах байрны урсгал зардлын төсвийг төлөвлөн аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст

1. Хүүхдийн эрх зөрчигдөх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудлаар бодлого зохицуулалтыг хийх, салбар дундын болон төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнаж ажиллах

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт

1. Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, дүн шинжилгээ хийж, Хүүхдийн төлөө зөвлөлийг мэдээллээр хангаж ажиллах.
2. Байгууллагын албан хаагчдаас албаны нууц задруулахгүй байх баталгааг авч хэвших
3. Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой баримт материалыг байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусган баталж, хадгаламжийн нэгж болгон архивд хүлээн авах, төрийн архивд шилжүүлж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ " гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 03 сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



УЛАМЖЛАХ САНАЛ:

Асуудал 1. Аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд төсвийн төслийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж хүргүүлсэн боловч ХГБХХЕГ-аас төсвийг төслөөр нь батлаагүй байна.

Санал 1: Аймгийн ХГБХХГ-аас боловсруулж хүргүүлсэн төсвийн төслийн хүртээмжтэй байдалд анхаарч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах саналыг ХГБХХЕГ-т ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

Асуудал 2. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүй байна.

Санал 2: Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг баталж мөрдүүлэх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

Асуудал 3. Хүүхэд хамгааллын мэргэжилтний орон тооны жишиг нормативыг тухайн орон нутгийн хүүхдийн тоотой уялдуулан батлаагүй байна.

Санал 3: Хүүхэд хамгааллын мэргэжилтний орон тооны жишиг нормативыг, тухайн орон нутгийн хүүхдийн тоотой уялдуулан баталж мөрдүүлэх саналыг ХГБХХЕГ-т ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:



ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

АРХАНГАЙ АЙМАГ
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР

1 дүгээр баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65141

Утас/Факс: (976) 7033 2886,

Цахим шуудан: arhangai@fcy.gov.mn

Цахим хуудас: <http://erhangai.fcy.gov.mn>

2024.10.25 № 364

танай _____-ны № _____-г

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Т.БАЙГАЛМАА ТАНАА

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж
буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн сэдэвт
аудитын тайлантай танилцлаа. Тайлантай
холбоотой санал, тайлбар байхгүй болно

ДАРГА



Б.БОЛОРМАА

652403390



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139

Утас/Факс: (976) 7033 3231,

Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,

Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2024.10.25 № 03/1468
танай 2024.10.25 -ны № 430 -т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тодорхой санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ГОМБОДОРЖ



652400901925



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/39

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитын тайланг аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газарт тус тус хүргүүлсүгэй.

4.Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Б.Азантунгалаг), аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, зэрүүлх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн /3/ тоот тушаалын хавсралт

"Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: АРА-2024/20-01-ШТА-ГА

№	Хүргүүлсэн шийдвэрийн			Хэрэгжилтийг хариуцах		
	Утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Тоо	Шийдвэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн А/75 дугаар захирамжаар "Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэм"-ийг баталсан. Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс нь аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэмд зааснаар "Хүүхдийн эрх зөрчихөх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудлаар бодлого зохицуулалтыг хийх, салбар дундын болон төсөл хөтөлбөрүүдийн үйлдвэр холбооо сайжруулах" чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.	-	1	Зөвлөмж	аймгийн ЗДТ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	И.Амаргүвшин
2	Аймгийн Хүүхдийн эрхийн Хууль зүйн хороо нь 2019-2023 онд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авалдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлэхгүй. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40.8-д заасантай нийцэхгүй байна		1	Албан шаардлага	Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын алба ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
3	Аймгийн Хүүхдийн эрхийн Хууль зүйн хороо нь гишүүдээс 2019-2021, 2023 онуудад Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг авч ажиллаагүй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40.8-д заасантай нийцэхгүй байна		1	Албан шаардлага	Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын алба ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
4	Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ИТХ-д тайлагнаагүй, салбар дундын үйл ажиллагааг үндэслэн зохицуулах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх үүргийг хэрэгжүүлэхгүй байна. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.1, Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 2.12, 2.13, 3.2-т заасантай нийцэхгүй байна.		1	Зөвлөмж	Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
5	Аймгийн ХТБХХГ-ын дэргэдэх Түр хамгаалах байрны 2019-2023 оны урсгал зардлыг орон нутгийн төсөвт тусган батлаагүй, аймгийн ХТБХХГ-ын цалингийн зардал болон хүүхэд хамгааллын зардалаас санхүүжүүлж байна. Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, Түр хамгааллын байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 9.2-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Зөвлөмж	Аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
6	Аймгийн ХТБХХГ нь хүүхэд хамгааллын мэдээллийн сантай боловч мэдээллийн санг гүйцэтгэлийн тайланд тусгаарлан тоо, мэдээ, Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн бүртгэлийн аде програмын мэдээ, 108 улсын childhelpline програмын мэдээ, ХТБХХГ-т хүргүүлсэн тоон мэдээгүдтэй тулгарах зөрүүтэй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 48.1-т "Хүүхэд хамгааллын мэдэсэн мэдээллийн сантай байна" гэж заасантай нийцэхгүй байна.	-	1	Зөвлөмж	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
7	Хүүхэд хамгааллын зардалаас 10,335.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 -т заасантай нийцэхгүй байна.	10,335.30	1	Албан шаардлага	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа



Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүн

8	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд 2019-2023 онд үзүүлсэн дэмжлэгийг түнэвлэн эрсдлийн программ руу түлгэлт хийхэд 140 хүүхэд буюу 89.7 хувь нь эрсдлийн able программд бүртгэлгүй, нөхцөл байдлын үнэлгээ хийсэн анхан шатны баримтгүй байна. Энэ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/120, А/178 дугаар тушаалын "Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам"-ын 1.4, 2.19-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Албан шаардлага	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
9	Аймгийн ХТБХХГ нь 2019-2023 онд албан хаагчдаас албаны нууц задруулахгүй байх баталгааг авч амжилтагүй. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой баримт материал, кейсийг хадгалахгүйг нэгж болгоогүй байна. Энэ нь Хүний хүйн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 2.1.6-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Зөвлөмж	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
10	Аймгийн ХТБХХГ нь Хяналт шинжилгээ үнэлгээг 2019, 2020, 2021 онуудад шалуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалын дагуу хийгээгүй, 2022 оны хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн боловч зөвлөмж, чиглэлийн биелэлтийг тосгоогүй, ажлын гайглан материалыг хадгалахгүйг нэгж болгоогүй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 34.1.12, 54.1.1-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Албан шаардлага	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
11	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээтэй холбоотой 2019-2023 оны анхан шатны баримт материалыг хөглөх хэргийн нэрийн жагсаалтад тусгаж батлаагүй, байгууллагын архивт хулган аваагүй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2.5, Архив, албан хэрэг, хөтөлбөрийн тухай хуулийн 24.1.9-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Зөвлөмж	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
12	Аймгийн ХТБХХГ-ын дэргэхэд Түр хамгаалах байр нь 2019-2023 онд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчдийн мэдээллийн санг бүрдүүлээгүй байна. Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21.1.1-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Албан шаардлага	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
13	Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг"-ийн дагуу аймгийн Хүүхэд хамгааллын бодлогыг шинэчлэн батлаагүй нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.1-д заасантай нийцэхгүй байна.	-	1	Зөвлөмж	Аймгийн ХТБХХГ-ын дарга	Б.Болормаа
14	Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2019-2023 онд Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого"-ын 5-д заасантай нийцэхгүй байна.	-	1	Албан шаардлага	Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	Ц.Мөнхбат
15	Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих үүргийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь ГТБХХГ, Соёл урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242/А/76 дугаар тушаалаар баталсан "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын 2.1-т заасантай нийцэхгүй байна.	-	1	Албан шаардлага	Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	Н.Сэр-Од
	Албан шаардлага	10,335.30	8			
	Зөвлөмж	-	7			
	НИЙТ ДҮН	10,335.30	15			

